



МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Ц.НЯМДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Б Ширэндэвийн гудамж 8/4, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26 75 33, И-мэйл: foreign@tojha.gov.mn,
Вэбсайт: www.tojha.gov.mn

2021.05.14 № 1/2264
танай -ны № -т

**Үзэл баримтлал баталж
хүргүүлэх тухай**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт заасны дагуу Кибер аюулгүй байдлын тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг баталж хүргүүлэв.

Кибер аюулгүй байдлын тухай хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж дараах саналтай байна:

1.Төслийн 4.1.2, 4.1.4, 4.1.10-т хэрэглэсэн мэдээлэлд хандах, нэвтрэх, мэдээлэлтэй танилцах, олж авах, хандсан, нэвтэрсэн зэрэг нэр томьёонуудын хоорондын ялгааг тодруулж, ямар тохиолдлуудыг хандах, нэвтрэх, танилцах зэрэгт хамааруулж байгааг ойлгомжтой болгох;

2.Төслийн 4.1.12-т "бүх төрлийн үйлдлийг" гэж тодорхойлсон байх бөгөөд бүх төрлийн гэдгийг ойлгомжтой болгох;

3.Төслийн 5.1.1-д кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд "мэргэжлийн нэгдмэл удирдлагатай байх" гэсэн зарчмыг баримтлахаар заасан бөгөөд "мэргэжлийн" гэдэгт юуг хамааруулахыг тодорхой болгох;

4.Төслийн зүйл, заалтуудад эшлэлийг хэт их хэрэглэснээс хуулийн зохицуулалтыг ойлгох, уншихад хүндрэлтэй нөхцөл үүсгэж байх тул шаардлагатай тохиолдолд эшлэлийг хэрэглэх. Тухайлбал, төслийн 7.2, 8.2, 8.3, 8.5, 8.6, 9.3, 9.5, 20.1 зэргийг дурдаж болохоор байна;

5.Төслийн 8.1-д энэ хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах хуулийн этгээд нь кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хийлгэхээр заасан бөгөөд уг хуулийн этгээд нь эрсдэлийн үнэлгээг өөрөө хийхэд хир хүндрэлтэй эсэх, заавал хөндлөнгийн этгээдээр хийлгэх нь тухайн хуулийн этгээдэд санхүүгийн ачаалал үүсгэх магадлалтай тул уг зохицуулалтыг анхаарах. Түүнчлэн эрсдэлийн үнэлгээ хийлгэхтэй холбоотойгоор харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас энэ төрлийн үйл ажиллагаа явуулахад эрх авах зохицуулалтыг 12.1.7-д заасан байх бөгөөд энэ талаар хуулинд тодорхой зохицуулалт тусгаагүй байх тул тодруулж тусгах.

A4 Сайд.2021

1-1601428

MAINTENANCE OF RECORDS

RECORDS SECTION

MAINTENANCE

10-1-5 14

13 70'

Мөн эрх олгох асуудал нь аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой эсэхийг тодруулах;

6.Төслийн 9.3-т заасан томъёоллыг дахин найруулж, ойлгомжтой болгох;

7.Төслийн 9.4-т заасан зохицуулалтыг хуулийн үйлчлэх хүрээнд тусгах;

8.Төслийн 11.1, 12.1, 13.1, 14.1, 15.1 зэрэгт заасан “чиг үүрэг”, “эрх, үүрэг”, “үүрэг” зэрэг нэр томъёонуудыг жигдэлж, зөв томъёоллыг тусгах;

9.Төслийн 12.1.5-д харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх эрх олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохоор заасан бөгөөд уг зохицуулалт нь аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл мөн эсэхийг тодруулж, хэрэв мөн бол Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулж, эрх олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгоход тавигдах шаардлага, үндэслэл зэргийг төсөлд тусгах.



Х.НЯМБААТАР

БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА

Ц.Нямдорж
Ц.НЯМДОРЖ

БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Х.Нямбаатар
Х.НЯМБААТАР

КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ын "Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг, хангах арга зам" хэмээх Гуравдугаар хэсгийн 3.6.1.3-т "Үндэсний мэдээллийн дэд бүтцэд халдах аюулаас хамгаалах, эдийн засаг, нийгмийн чадавхыг сулруулах оролдлоготой тэмцэх чадавхыг бий болгоно" гэж, 3.6.1.5-д "Мэдээллийн аюулгүй байдлын үндэсний хэмжээний бодлого, эрх зүйн зохицуулалт, стандарт, удирдлага, зохион байгуулалт, сургалтын тогтолцоог бий болгож нийгэм дэх ойлголт, мэдлэгийг төлөвшүүлнэ" гэж, 3.6.1.6-д "Төр, хувийн хэвшлийн байгууллагад мэдээллийн аюулгүй байдлын бодлого, дэг, эрсдэлийн удирдлага, дотоод аудит, үнэлгээний чадавхыг бий болгоно," гэж, 3.6.1.11-д "Кибер орчин дахь гэмт явдалтай тэмцэх, аливаа гэмт хэргийг илрүүлэх, нотлоход тооцоолох хэрэгслийн криминалистик техникийн шинжилгээ ашиглах үндэсний чадавхыг бий болгоно." гэж, 3.6.2.4-т "Үндэсний мэдээллийн орчин, дэд бүтцийн эмзэг байдлыг бууруулах тогтолцоог бүрдүүлнэ" гэж, 3.6.3.5-д "Төрийн байгууллага, онц чухал дэд бүтцийн объектод чиг үүрэгт суурилсан хандалтын удирдлага, сүлжээний хяналт-шинжилгээ хийх, халдлагыг илрүүлж таслан зогсоох чадварыг бий болгоно." гэж, 3.6.4.6-д "Үндэсний мэдээллийн дэд бүтцийн бэлэн байдал, халдлагыг сөрөн зогсох, даван гарах чадварыг бий болгож, тасралтгүй ажиллагааг хангах, сэргээн ажиллуулах төлөвлөлтийг хэвшүүлж, сүлжээний хяналт шинжилгээ, анхааруулгын төв байгуулж, компьютерын онцгой байдлын үед хариу үйлдэл хийх үндэсний тогтолцоог дэмжин хөгжүүлнэ" гэж тус тус заасан.

Түүнчлэн, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021–2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 5.3.1-д "Мэдээллийн аюулгүй байдлын, цахим гарын үсгийн, мэдээллийн сангийн, хувь хүний мэдээллийн аюулгүй байдлын зэрэг цахим засаглалыг хөгжүүлэхэд шаардагдах хууль тогтоомжийг боловсруулж батлуулан, түүнтэй нийцүүлэн холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулна." гэж, мөн 7.5-д "Төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулж, өрсөлдөх чадвар бий болгоно." гэж тус тус заасан.

Мөн Засгийн газрын 2017 оны 47 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого"-ын 3.8.1-д "Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хууль, эрх зүйн зохицуулалтын

зохицуулалтын орчныг бүрдүүлэх”, 3 8 2-т “Үндэсний мэдээллийн дэд бүтцэд халдах зэрэг кибер гэмт хэрэгтэй тэмцэх чадавхыг бий болгоно” гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн “Засаглалын бодлого” хэмээх Дөрөвдүгээр бүлгийн 4 1 2-т “Хүний эрхийг дээдэлсэн, цахим засаглалыг дэмжсэн, технологийн аюулгүй, зохистой харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ түвшинд гаргана” гэж, 4 1 6-д “Үндэсний ашиг сонирхлыг хамгаалсан төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангасан мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлж, чадавхыг нэмэгдүүлнэ” гэж тус тус заасан

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 1 дүгээрт Монгол Улсын Засгийн газар Кибер аюулгүй байдлын тухай хуулийн төслийг санаачлан боловсруулахаар тусгасан

2 Мэдээлэл, харилцаа холбооны технологи маш хурдацтай хөгжиж буй өнөө үед улс орнууд кибер аюулгүй байдлыг хангах асуудалд ихээхэн анхаарал хандуулах болсон. 2020 оны 10 дугаар сарын байдлаар дэлхийн хүн амын талаас илүү буюу 59 хувь, манай улсын хүн амын 68 хувь нь интернэт хэрэглэж, төр, хувийн хэвшлийн байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжих болсон нь кибер орчин дахь мэдээллийн хүртээмжтэй, бүрэн бүтэн байдлыг нь хангах шаардлага давхар тавигдах болсон

Дэлхийн улс орнууд цахим халдлага, цахим гэмт хэргээс үүдэн өнгөрсөн 2020 онд ойролцоогоор 10 5 их наяд Америк долларын хохирол амссан бөгөөд энэ нь дэлхийн нийт эдийн засгийн 1 хувьтай тэнцэх хэмжээний дүн юм

Иймд улс орнууд цахим мэдээллийн аюулгүй байдлын асуудлыг үндэсний аюулгүй байдлын тэргүүлэх зорилтын нэг хэмээн тодорхойлж, үндэсний хэмжээнд стратеги гаргаж хэрэгжүүлэх, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, техник технологи, хүний нөөцөө бэхжүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж, энэ чиглэлд төсвийн хөрөнгийн багагүй хувийг зарцуулж байна. Тухайлбал, Америкийн Нэгдсэн Улс кибер аюулгүй байдлаа хангахад зориулж 2018 онд 18 7, 2019 онд 16 9, 2020 онд 18 7 тэрбум ам доллар зарцуулсан бөгөөд 2021 онд 18 7 тэрбум ам доллар төсөвлөсөн байна

Сүүлийн 20 жилийн хугацаанд дэлхийн 79 орон цахим аюулгүй байдлын үндэсний стратеги боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн бол өнгөрсөн 10 жилийн хугацаанд Америк, Орос, Хятад, Солонгос, Япон, Хорват, Унгар, Гүрж, Литва, Латви, Сингапур, Эстони зэрэг улс орнууд цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр бие даасан хуулиа батлан гаргасан байна

Монгол Улсын хувьд өнөөдрийн байдлаар мэдээлэл, мэдээллийн сан, цахим мэдээллийн системтэй холбоотой эрх зүйн зохицуулалт 154 хуулиар зохицуулагдаж байгаа боловч тэдгээрийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нэгдсэн зохицуулалтгүй байна. Өөрөөр хэлбэл Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д мэдээллийн аюулгүй байдлыг үндэсний аюулгүй байдлын нэг бүрэлдэхүүн хэмээн тодорхойлж, Монгол Улсын

мэдээллийн аюулгүй байдлын үндэсний стратеги /Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр/-ийг 2010-2015 онд хэрэгжүүлсэн боловч хөтөлбөрийн биелэлт 50 хувиас бага биелэлттэй гарсан

Монгол Улсад төрийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг тухайн байгууллага өөрөө хариуцан ажиллаж байгаа бөгөөд “Үндэсний Дата төв” УТҮГ төрийн байгууллагын системийн тасалдалгүй, найдвартай ажиллагааг Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газар төрийн нэгдсэн сүлжээний аюулгүй байдлыг хариуцан ажилладаг

Дээрх байгууллагуудаас 2013-2020 онд кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээнд хийсэн тайлангаас үзэхэд төрийн байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн түвшин “өндөр эрсдэлтэй”, “маш өндөр эрсдэлтэй” гэсэн 2 ангилалд, онц чухал дэд бүтэцтэй байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн түвшин “өндөр эрсдэлтэй” ангилалд хамаарч байна

Халдлага илрүүлэлтийн хувьд 2021 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2 дугаар сарын 18-ны өдрийн хооронд төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд ноцтой түвшний /critical/ 462 625, өндөр түвшний /high/ 316 765 халдлагыг илрүүлэн таслан зогсоож холбогдох арга хэмжээ авсан байна

“Үндэсний дата төв” УТҮГ-т чиглэсэн зорилтот /target/ халдлага 2013 оноос эрчимжиж эхэлсэн бөгөөд холбогдох байгууллагууд тухай бүрд нь халдлагатай холбоотой арга хэмжээг авч төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллаж таслан зогсоож байна “Үндэсний дата төв” УТҮГ-ын цахим хамгаалалтын системийн мэдээллээс үзэхэд төрийн байгууллагуудын вэб сайтуудын серверт илрүүлсэн халдлагаас дийлэнх хувийг дотоодоос болон Хятад, Орос, Америк, Герман улсад бүртгэлтэй хостуудаас хийсэн халдлагууд бүртгэгдэж байна Сүүлийн зургаан сарын хугацаанд өдөрт дунджаар 66 сая орчим хандалт хийгдэж байгаагаас 14,6 сая орчим нь халдлагын шинжтэй гэж бүртгэгддэг Төрийн байгууллагуудад чиглэж буй цахим халдлагад мэдээлэл хулгайлах зорилготой халдлагууд дийлэнх хувийг эзэлдэг байна

Цагдаагийн ерөнхий газрын 2020 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээгээр Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэг 2019 онд улсын хэмжээнд 57 тохиолдол байсан бол 2020 онд 146 болж 3 дахин нэмэгдсэн байна ¹

Нэгдсэн үндэстний байгууллагын төрөлжсөн агентлаг болох Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас гишүүн 193 орны хүрээнд гаргадаг кибер аюулгүй байдлын индексийг тухайн улсын хууль эрх зүйн орчин, техникийн хувьд хэрэгжүүлж буй арга хэмжээ /үндэсний CIRT байгууллага, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад тавигдах стандарт, шаардлагууд/, зохион байгуулалтын арга хэмжээ /үндэсний стратеги, хөтөлбөрийн баримт бичиг, түүнийг хэрэгжүүлэх байгууллага/ чадавх бүрдүүлэх /үндэсний цахим аюулгүй байдлын сургалтын тогтолцоо/, хамтын ажиллагаа /олон улсын гэрээ, хэлцэлд нэгдсэн байдал, бусад орнуудтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээ, дотоодын байгууллагууд хоорондын хамтын ажиллагаа/ гэсэн үндсэн үзүүлэлт, 25 дэд үзүүлэлтийн хүрээнд гаргадаг Манай улсын хувьд хамгийн гол үзүүлэлт болох хууль эрх зүйн орчин бүрдээгүй, үндэсний CIRT байгууллага байхгүй, хамтын ажиллагаа дутмаг зэрэг

¹ /<https://police.gov.mn/a/5428/>

үндэслэлээр 2017 онд 104 дүгээр байранд, 2018 онд 85 дугаар байранд эрэмбэлэгдсэн байна

Иймд Монгол Улсад төр, хүн, хуулийн этгээдийн кибер аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэх, аюул заналыг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, онц чухал мэдээллийн дэд бүтцийг хамгаалах хуулийн зохицуулалт зайлшгүй шаардлагатай байгаа тул Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Кибер аюулгүй байдлын тухай анхдагч хуулийн төсөл боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна

Хоёр.Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ, хуулийн төслийн ерөнхий бүтэц

Кибер аюулгүй байдлын тухай хуулийн төсөл нь 5 бүлэгтэй байна

Хуулийн төслийн нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, Кибер аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, нэр томъёоны тодорхойлолт, кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тогтооно

Хуулийн төслийн зорилтод кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны зарчим, эрх зүйн үндсийг тогтоох, кибер орчин дахь мэдээллийн бүрэн бүтэн, хүртээмжтэй, нууцлагдсан байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахаар тусгана

Хуулийн төслийн үйлчлэх хүрээ нь кибер аюулгүй байдлыг хангахтай холбогдон төр, хүн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг уялдуулан зохицуулах, зохион байгуулах, хяналтыг хэрэгжүүлэх харилцаанд үйлчлэх бөгөөд хамрах хүрээний хувьд төрийн байгууллага, онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага, кибер орчинд дундын мэдээллийн систем боловсруулах, хадгалах, түгээх, цахим тооцооллын үйлчилгээ эрхэлж буй хуулийн этгээд болон түүний хэвийн үйл ажиллагааг хангахад мэдээллийн технологийн чиглэлээр дэмжлэг үзүүлж буй хуулийн этгээд, гадаадын иргэн, хуулийн этгээдэд үйлчилнэ

Хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлж, энэ хүрээнд хэрэгжүүлэх кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ болон мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх харилцааг тогтооно

Хуулийн төслийн гуравдугаар бүлэгт кибер аюулгүй байдлыг хангах тогтолцоо буюу кибер аюулгүй байдлыг хангах талаар Улсын Их Хурал, Засгийн газрын бүрэн эрх, харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, харилцаа холбооны зохицуулах хороо, тагнуулын байгууллагын эрх, үүрэг, цагдаагийн байгууллага, төрийн бусад байгууллага, онц чухал дэд бүтэцтэй байгууллага, хувийн хэвшлийн байгууллага, иргэний үүргийг тогтооно

Хуулийн төслийн дөрөвдүгээр бүлэгт кибер халдлага, зөрчилтэй тэмцэх төвүүд, тэдгээрийн чиг үүргийн уялдаа холбоог хангах зохицуулалтыг тусгана

Хуулийн төслийн тавдугаар бүлэгт кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд тавих хяналт, хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох хугацааг тусгана

Гурав.Хууль батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар эдийн засаг, нийгмийн дараах нөлөө, үр дагавар гарна гэж үзэж байна

1 “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”, “Төрөөс мэдээлэл харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого 2017-2025” зэрэг баримт бичгүүдэд тусгагдсан мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилтуудыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэж, Монгол Улсын мэдээллийн аюулгүй байдлыг хангахад эерэг нөлөө үзүүлнэ

2 Кибер аюулгүй байдлыг хангах үндэсний тогтолцоо бүрдэж, кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хяналт тавих, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах боломж бүрдэнэ

3 Кибер халдлага зөрчилтэй тэмцэх төвүүдийг байгуулж, кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авах, нөхөн сэргээх үндэсний чадавхыг бэхжүүлнэ

4 Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг төр-хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа үр дүнтэй, шуурхай хэрэгжих нөхцөлийг бүрдүүлнэ

5 Иргэдийн кибер аюулгүй байдлын талаарх ойлголт, мэдлэг, хариуцлага дээшилж өөрийн эзэмшиж, ашиглаж байгаа мэдээллийн систем, төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангах чадавх сайжирна

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомж

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид бүрэн нийцэх бөгөөд шинээр боловсруулж байгаа Хүний хувийн мэдээлэлийг хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн тухай хуулийн төслүүдтэй нийцүүлэн хуулийн төслийг боловсруулна Кибер аюулгүй байдлын тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг хуулийн төслийг боловсруулна

---oOo---

БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Х.НЯМБААТАР

КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ын "Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг, хангах арга зам" хэмээх Гуравдугаар хэсгийн 3.6.1.3-т "Үндэсний мэдээллийн дэд бүтцэд халдах аюулаас хамгаалах, эдийн засаг, нийгмийн чадавхыг сулруулах оролдлоготой тэмцэх чадавхыг бий болгоно" гэж, 3.6.1.5-д "Мэдээллийн аюулгүй байдлын үндэсний хэмжээний бодлого, эрх зүйн зохицуулалт, стандарт, удирдлага, зохион байгуулалт, сургалтын тогтолцоог бий болгож нийгэм дэх ойлголт, мэдлэгийг төлөвшүүлнэ" гэж, 3.6.1.6-д "Төр, хувь хэвшлийн байгууллагад мэдээллийн аюулгүй байдлын бодлого, дэг, эрсдэл удирдлага, дотоод аудит, үнэлгээний чадавхыг бий болгоно." гэж, 3.6.1.11-д "К. орчин дахь гэмт явдалтай тэмцэх, аливаа гэмт хэргийг илрүүлэх, нотлох тооцоолох хэрэгслийн криминалистик техникийн шинжилгээ ашиглах үндэс чадавхыг бий болгоно." гэж, 3.6.2.4-т "Үндэсний мэдээллийн орчин, дэд бүтцийн эмзэг байдлыг бууруулах тогтолцоог бүрдүүлнэ" гэж, 3.6.3.5-д "Төрийн байгууллага, онц чухал дэд бүтцийн объектод чиг үүрэгт суурилсан хандалтын удирдлага, сүлжээний хяналт-шинжилгээ хийх, халдлагыг илрүүлж таслан зогсоох чадварыг бий болгоно." гэж, 3.6.4.6-д "Үндэсний мэдээллийн дэд бүтцийн бэлэн байдал, халдлагыг сөрөн зогсох, даван гарах чадварыг бий болгож, тасралтгүй ажиллагааг хангах, сэргээн ажиллуулах төлөвлөлтийг хэвшүүлж, сүлжээний хяналт шинжилгээ, анхааруулгын төв байгуулж, компьютерын онцгой байдлын үед хариу үйлдэл хийх үндэсний тогтолцоог дэмжин хөгжүүлнэ" гэж тус тус заасан.

Түүнчлэн, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021–2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа"-ны 5.3.1-д "Мэдээллийн аюулгүй байдлын, цахим гарын үсгийн, мэдээллийн сангийн, хувь хүний мэдээллийн аюулгүй байдлын зэрэг цахим засаглалыг хөгжүүлэхэд шаардагдах хууль тогтоомжийг боловсруулж батлуулан, түүнтэй нийцүүлэн холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулна." гэж, мөн 7.5-д "Төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулж, өрсөлдөх чадвар бий болгоно." гэж тус тус заасан.

Мөн Засгийн газрын 2017 оны 47 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого"-ын 3.8.1-д "Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хууль, эрх зүйн зохицуулалтын

зохицуулалтын орчныг бүрдүүлэх”, 3 8 2-т “Үндэсний мэдээллийн дэд бүтцэд халдах зэрэг кибер гэмт хэрэгтэй тэмцэх чадавхыг бий болгоно” гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн “Засаглалын бодлого” хэмээх Дөрөвдүгээр бүлгийн 4 1 2-т “Хүний эрхийг дээдэлсэн, цахим засаглалыг дэмжсэн, технологийн аюулгүй, зохистой харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ түвшинд гаргана” гэж, 4 1 6-д “Үндэсний ашиг сонирхлыг хамгаалсан төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангасан мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлж, чадавхыг нэмэгдүүлнэ” гэж тус тус заасан

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 1 дүгээрт Монгол Улсын Засгийн газар Кибер аюулгүй байдлын тухай хуулийн төслийг санаачлан боловсруулахаар тусгасан

2 Мэдээлэл, харилцаа холбооны технологи маш хурдацтай хөгжиж буй өнөө үед улс орнууд кибер аюулгүй байдлыг хангах асуудалд ихээхэн анхаарал хандуулах болсон. 2020 оны 10 дугаар сарын байдлаар дэлхийн хүн амын талаас илүү буюу 59 хувь, манай улсын хүн амын 68 хувь нь интернэт хэрэглэж, төр, хувийн хэвшлийн байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжих болсон нь кибер орчин дахь мэдээллийн хүртээмжтэй, бүрэн бүтэн байдлыг нь хангах шаардлага давхар тавигдах болсон

Дэлхийн улс орнууд цахим халдлага, цахим гэмт хэргээс үүдэн өнгөрсөн 2020 онд ойролцоогоор 10 5 их наяд Америк долларын хохирол амссан бөгөөд энэ нь дэлхийн нийт эдийн засгийн 1 хувьтай тэнцэх хэмжээний дүн юм

Иймд улс орнууд цахим мэдээллийн аюулгүй байдлын асуудлыг үндэсний аюулгүй байдлын тэргүүлэх зорилтын нэг хэмээн тодорхойлж, үндэсний хэмжээнд стратеги гаргаж хэрэгжүүлэх, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, техник технологи, хүний нөөцөө бэхжүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж, энэ чиглэлд төсвийн хөрөнгийн багагүй хувийг зарцуулж байна. Тухайлбал, Америкийн Нэгдсэн Улс кибер аюулгүй байдлаа хангахад зориулж 2018 онд 18 7, 2019 онд 16 9, 2020 онд 18 7 тэрбум ам доллар зарцуулсан бөгөөд 2021 онд 18 7 тэрбум ам доллар төсөвлөсөн байна

Сүүлийн 20 жилийн хугацаанд дэлхийн 79 орон цахим аюулгүй байдлын үндэсний стратеги боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн бол өнгөрсөн 10 жилийн хугацаанд Америк, Орос, Хятад, Солонгос, Япон, Хорват, Унгар, Гүрж, Литва, Латви, Сингапур, Эстони зэрэг улс орнууд цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр бие даасан хуулиа батлан гаргасан байна

Монгол Улсын хувьд өнөөдрийн байдлаар мэдээлэл, мэдээллийн сан, цахим мэдээллийн системтэй холбоотой эрх зүйн зохицуулалт 154 хуулиар зохицуулагдаж байгаа боловч тэдгээрийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нэгдсэн зохицуулалтгүй байна. Өөрөөр хэлбэл Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д мэдээллийн аюулгүй байдлыг үндэсний аюулгүй байдлын нэг бүрэлдэхүүн хэмээн тодорхойлж, Монгол Улсын

мэдээллийн аюулгүй байдлын үндэсний стратеги /Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр/-ийг 2010-2015 онд хэрэгжүүлсэн боловч хөтөлбөрийн биелэлт 50 хувиас бага биелэлттэй гарсан

Монгол Улсад төрийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг тухайн байгууллага өөрөө хариуцан ажиллаж байгаа бөгөөд “Үндэсний Дата төв” УТҮГ төрийн байгууллагын системийн тасалдалгүй, найдвартай ажиллагааг Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газар төрийн нэгдсэн сүлжээний аюулгүй байдлыг хариуцан ажилладаг

Дээрх байгууллагуудаас 2013-2020 онд кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээнд хийсэн тайлангаас үзэхэд төрийн байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн түвшин “өндөр эрсдэлтэй”, “маш өндөр эрсдэлтэй” гэсэн 2 ангилалд, онц чухал дэд бүтэцтэй байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн түвшин “өндөр эрсдэлтэй” ангилалд хамаарч байна

Халдлага илрүүлэлтийн хувьд 2021 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2 дугаар сарын 18-ны өдрийн хооронд төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд ноцтой түвшний /critical/ 462 625, өндөр түвшний /high/ 316 765 халдлагыг илрүүлэн таслан зогсоож холбогдох арга хэмжээ авсан байна

“Үндэсний дата төв” УТҮГ-т чиглэсэн зорилтот /target/ халдлага 2013 оноос эрчимжиж эхэлсэн бөгөөд холбогдох байгууллагууд тухай бүрд нь халдлагатай холбоотой арга хэмжээг авч төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллаж таслан зогсоож байна “Үндэсний дата төв” УТҮГ-ын цахим хамгаалалтын системийн мэдээллээс үзэхэд төрийн байгууллагуудын вэб сайтуудын серверт илрүүлсэн халдлагаас дийлэнх хувийг дотоодоос болон Хятад, Орос, Америк, Герман улсад бүртгэлтэй хостуудаас хийсэн халдлагууд бүртгэгдэж байна Сүүлийн зургаан сарын хугацаанд өдөрт дунджаар 66 сая орчим хандалт хийгдэж байгаагаас 14,6 сая орчим нь халдлагын шинжтэй гэж бүртгэгддэг Төрийн байгууллагуудад чиглэж буй цахим халдлагад мэдээлэл хулгайлах зорилготой халдлагууд дийлэнх хувийг эзэлдэг байна

Цагдаагийн ерөнхий газрын 2020 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээгээр Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэг 2019 онд улсын хэмжээнд 57 тохиолдол байсан бол 2020 онд 146 болж 3 дахин нэмэгдсэн байна ¹

Нэгдсэн үндэстний байгууллагын төрөлжсөн агентлаг болох Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас гишүүн 193 орны хүрээнд гаргадаг кибер аюулгүй байдлын индексийг тухайн улсын хууль эрх зүйн орчин, техникийн хувьд хэрэгжүүлж буй арга хэмжээ /үндэсний CIRT байгууллага, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад тавигдах стандарт, шаардлагууд/, зохион байгуулалтын арга хэмжээ /үндэсний стратеги, хөтөлбөрийн баримт бичиг, түүнийг хэрэгжүүлэх байгууллага/ чадавх бүрдүүлэх /үндэсний цахим аюулгүй байдлын сургалтын тогтолцоо/, хамтын ажиллагаа /олон улсын гэрээ, хэлцэлд нэгдсэн байдал, бусад орнуудтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээ, дотоодын байгууллагууд хоорондын хамтын ажиллагаа/ гэсэн үндсэн үзүүлэлт, 25 дэд үзүүлэлтийн хүрээнд гаргадаг Манай улсын хувьд хамгийн гол үзүүлэлт болох хууль эрх зүйн орчин бүрдээгүй, үндэсний CIRT байгууллага байхгүй, хамтын ажиллагаа дутмаг зэрэг

¹ /<https://police.gov.mn/a/5428/>

үндэслэлээр 2017 онд 104 дүгээр байранд, 2018 онд 85 дугаар байранд эрэмбэлэгдсэн байна

Иймд Монгол Улсад төр, хүн, хуулийн этгээдийн кибер аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэх, аюул заналыг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, онц чухал мэдээллийн дэд бүтцийг хамгаалах хуулийн зохицуулалт зайлшгүй шаардлагатай байгаа тул Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Кибер аюулгүй байдлын тухай анхдагч хуулийн төсөл боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна

Хоёр.Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ, хуулийн төслийн ерөнхий бүтэц

Кибер аюулгүй байдлын тухай хуулийн төсөл нь 5 бүлэгтэй байна

Хуулийн төслийн нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, Кибер аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, нэр томъёоны тодорхойлолт, кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тогтооно

Хуулийн төслийн зорилтод кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны зарчим, эрх зүйн үндсийг тогтоох, кибер орчин дахь мэдээллийн бүрэн бүтэн, хүртээмжтэй, нууцлагдсан байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахаар тусгана

Хуулийн төслийн үйлчлэх хүрээ нь кибер аюулгүй байдлыг хангахтай холбогдон төр, хүн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг уялдуулан зохицуулах, зохион байгуулах, хяналтыг хэрэгжүүлэх харилцаанд үйлчлэх бөгөөд хамрах хүрээний хувьд төрийн байгууллага, онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага, кибер орчинд дундын мэдээллийн систем боловсруулах, хадгалах, түгээх, цахим тооцооллын үйлчилгээ эрхэлж буй хуулийн этгээд болон түүний хэвийн үйл ажиллагааг хангахад мэдээллийн технологийн чиглэлээр дэмжлэг үзүүлж буй хуулийн этгээд, гадаадын иргэн, хуулийн этгээдэд үйлчилнэ

Хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлж, энэ хүрээнд хэрэгжүүлэх кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ болон мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх харилцааг тогтооно

Хуулийн төслийн гуравдугаар бүлэгт кибер аюулгүй байдлыг хангах тогтолцоо буюу кибер аюулгүй байдлыг хангах талаар Улсын Их Хурал, Засгийн газрын бүрэн эрх, харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, харилцаа холбооны зохицуулах хороо, тагнуулын байгууллагын эрх, үүрэг, цагдаагийн байгууллага, төрийн бусад байгууллага, онц чухал дэд бүтэцтэй байгууллага, хувийн хэвшлийн байгууллага, иргэний үүргийг тогтооно

Хуулийн төслийн дөрөвдүгээр бүлэгт кибер халдлага, зөрчилтэй тэмцэх төвүүд, тэдгээрийн чиг үүргийн уялдаа холбоог хангах зохицуулалтыг тусгана

Хуулийн төслийн тавдугаар бүлэгт кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд тавих хяналт, хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох хугацааг тусгана

Гурав.Хууль батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар эдийн засаг, нийгмийн дараах нөлөө, үр дагавар гарна гэж үзэж байна

1 “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”, “Төрөөс мэдээлэл харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого 2017-2025” зэрэг баримт бичгүүдэд тусгагдсан мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилтуудыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэж, Монгол Улсын мэдээллийн аюулгүй байдлыг хангахад эерэг нөлөө үзүүлнэ

2 Кибер аюулгүй байдлыг хангах үндэсний тогтолцоо бүрдэж, кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хяналт тавих, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах боломж бүрдэнэ

3 Кибер халдлага зөрчилтэй тэмцэх төвүүдийг байгуулж, кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авах, нөхөн сэргээх үндэсний чадавхыг бэхжүүлнэ

4 Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг төр-хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа үр дүнтэй, шуурхай хэрэгжих нөхцөлийг бүрдүүлнэ

5 Иргэдийн кибер аюулгүй байдлын талаарх ойлголт, мэдлэг, хариуцлага дээшилж өөрийн эзэмшиж, ашиглаж байгаа мэдээллийн систем, төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангах чадавх сайжирна

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомж

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид бүрэн нийцэх бөгөөд шинээр боловсруулж байгаа Хүний хувийн мэдээлэлийг хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн тухай хуулийн төслүүдтэй нийцүүлэн хуулийн төслийг боловсруулна Кибер аюулгүй байдлын тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг хуулийн төслийг боловсруулна

---oOo---

БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Х.НЯМБААТАР

КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ын "Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг, хангах арга зам" хэмээх Гуравдугаар хэсгийн 3.6.1.3-т "Үндэсний мэдээллийн дэд бүтцэд халдах аюулаас хамгаалах, эдийн засаг, нийгмийн чадавхыг сулруулах оролдлоготой тэмцэх чадавхыг бий болгоно" гэж, 3.6.1.5-д "Мэдээллийн аюулгүй байдлын үндэсний хэмжээний бодлого, эрх зүйн зохицуулалт, стандарт, удирдлага, зохион байгуулалт, сургалтын тогтолцоог бий болгож нийгэм дэх ойлголт, мэдлэгийг төлөвшүүлнэ" гэж, 3.6.1.6-д "Төр, хувийн хэвшлийн байгууллагад мэдээллийн аюулгүй байдлын бодлого, дэг, эрсдэлийн удирдлага, дотоод аудит, үнэлгээний чадавхыг бий болгоно." гэж, 3.6.1.11-д "Кибер орчин дахь гэмт явдалтай тэмцэх, аливаа гэмт хэргийг илрүүлэх, нотлоход тооцоолох хэрэгслийн криминалистик техникийн шинжилгээ ашиглах үндэсний чадавхыг бий болгоно." гэж, 3.6.2.4-т "Үндэсний мэдээллийн орчин, дэд бүтцийн эмзэг байдлыг бууруулах тогтолцоог бүрдүүлнэ" гэж, 3.6.3.5-д "Төрийн байгууллага, онц чухал дэд бүтцийн объектод чиг үүрэгт суурилсан хандалтын удирдлага, сүлжээний хяналт-шинжилгээ хийх, халдлагыг илрүүлж таслан зогсоох чадварыг бий болгоно." гэж, 3.6.4.6-д "Үндэсний мэдээллийн дэд бүтцийн бэлэн байдал, халдлагыг сөрөн зогсох, даван гарах чадварыг бий болгож, тасралтгүй ажиллагааг хангах, сэргээн ажиллуулах төлөвлөлтийг хэвшүүлж, сүлжээний хяналт шинжилгээ, анхааруулгын төв байгуулж, компьютерын онцгой байдлын үед хариу үйлдэл хийх үндэсний тогтолцоог дэмжин хөгжүүлнэ" гэж тус тус заасан.

Түүнчлэн, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021–2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа"-ны 5.3.1-д "Мэдээллийн аюулгүй байдлын, цахим гарын үсгийн, мэдээллийн сангийн, хувь хүний мэдээллийн аюулгүй байдлын зэрэг цахим засаглалыг хөгжүүлэхэд шаардагдах хууль тогтоомжийг боловсруулж батлуулан, түүнтэй нийцүүлэн холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулна." гэж, мөн 7.5-д "Төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулж, өрсөлдөх чадвар бий болгоно." гэж тус тус заасан.

Мөн Засгийн газрын 2017 оны 47 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого"-ын 3.8.1-д "Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хууль, эрх зүйн зохицуулалтын

зохицуулалтын орчныг бүрдүүлэх”, 3 8 2-т “Үндэсний мэдээллийн дэд бүтцэд халдах зэрэг кибер гэмт хэрэгтэй тэмцэх чадавхыг бий болгоно” гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн “Засаглалын бодлого” хэмээх Дөрөвдүгээр бүлгийн 4 1 2-т “Хүний эрхийг дээдэлсэн, цахим засаглалыг дэмжсэн, технологийн аюулгүй, зохистой харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ түвшинд гаргана” гэж, 4 1 6-д “Үндэсний ашиг сонирхлыг хамгаалсан төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангасан мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлж, чадавхыг нэмэгдүүлнэ” гэж тус тус заасан

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 1 дүгээрт Монгол Улсын Засгийн газар Кибер аюулгүй байдлын тухай хуулийн төслийг санаачлан боловсруулахаар тусгасан

2 Мэдээлэл, харилцаа холбооны технологи маш хурдацтай хөгжиж буй өнөө үед улс орнууд кибер аюулгүй байдлыг хангах асуудалд ихээхэн анхаарал хандуулах болсон. 2020 оны 10 дугаар сарын байдлаар дэлхийн хүн амын талаас илүү буюу 59 хувь, манай улсын хүн амын 68 хувь нь интернэт хэрэглэж, төр, хувийн хэвшлийн байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжих болсон нь кибер орчин дахь мэдээллийн хүртээмжтэй, бүрэн бүтэн байдлыг нь хангах шаардлага давхар тавигдах болсон

Дэлхийн улс орнууд цахим халдлага, цахим гэмт хэргээс үүдэн өнгөрсөн 2020 онд ойролцоогоор 10 5 их наяд Америк долларын хохирол амссан бөгөөд энэ нь дэлхийн нийт эдийн засгийн 1 хувьтай тэнцэх хэмжээний дүн юм

Иймд улс орнууд цахим мэдээллийн аюулгүй байдлын асуудлыг үндэсний аюулгүй байдлын тэргүүлэх зорилтын нэг хэмээн тодорхойлж, үндэсний хэмжээнд стратеги гаргаж хэрэгжүүлэх, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, техник технологи, хүний нөөцөө бэхжүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж, энэ чиглэлд төсвийн хөрөнгийн багагүй хувийг зарцуулж байна. Тухайлбал, Америкийн Нэгдсэн Улс кибер аюулгүй байдлаа хангахад зориулж 2018 онд 18 7, 2019 онд 16 9, 2020 онд 18 7 тэрбум ам доллар зарцуулсан бөгөөд 2021 онд 18 7 тэрбум ам доллар төсөвлөсөн байна

Сүүлийн 20 жилийн хугацаанд дэлхийн 79 орон цахим аюулгүй байдлын үндэсний стратеги боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн бол өнгөрсөн 10 жилийн хугацаанд Америк, Орос, Хятад, Солонгос, Япон, Хорват, Унгар, Гүрж, Литва, Латви, Сингапур, Эстони зэрэг улс орнууд цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр бие даасан хуулиа батлан гаргасан байна

Монгол Улсын хувьд өнөөдрийн байдлаар мэдээлэл, мэдээллийн сан, цахим мэдээллийн системтэй холбоотой эрх зүйн зохицуулалт 154 хуулиар зохицуулагдаж байгаа боловч тэдгээрийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нэгдсэн зохицуулалтгүй байна. Өөрөөр хэлбэл Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д мэдээллийн аюулгүй байдлыг үндэсний аюулгүй байдлын нэг бүрэлдэхүүн хэмээн тодорхойлж, Монгол Улсын

мэдээллийн аюулгүй байдлын үндэсний стратеги /Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр/-ийг 2010-2015 онд хэрэгжүүлсэн боловч хөтөлбөрийн биелэлт 50 хувиас бага биелэлттэй гарсан

Монгол Улсад төрийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг тухайн байгууллага өөрөө хариуцан ажиллаж байгаа бөгөөд “Үндэсний Дата төв” УТҮГ төрийн байгууллагын системийн тасалдалгүй, найдвартай ажиллагааг Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газар төрийн нэгдсэн сүлжээний аюулгүй байдлыг хариуцан ажилладаг

Дээрх байгууллагуудаас 2013-2020 онд кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээнд хийсэн тайлангаас үзэхэд төрийн байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн түвшин “өндөр эрсдэлтэй”, “маш өндөр эрсдэлтэй” гэсэн 2 ангилалд, онц чухал дэд бүтэцтэй байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн түвшин “өндөр эрсдэлтэй” ангилалд хамаарч байна

Халдлага илрүүлэлтийн хувьд 2021 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2 дугаар сарын 18-ны өдрийн хооронд төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд ноцтой түвшний /critical/ 462 625, өндөр түвшний /high/ 316 765 халдлагыг илрүүлэн таслан зогсоож холбогдох арга хэмжээ авсан байна

“Үндэсний дата төв” УТҮГ-т чиглэсэн зорилтот /target/ халдлага 2013 оноос эрчимжиж эхэлсэн бөгөөд холбогдох байгууллагууд тухай бүрд нь халдлагатай холбоотой арга хэмжээг авч төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллаж таслан зогсоож байна “Үндэсний дата төв” УТҮГ-ын цахим хамгаалалтын системийн мэдээллээс үзэхэд төрийн байгууллагуудын вэб сайтуудын серверт илрүүлсэн халдлагаас дийлэнх хувийг дотоодоос болон Хятад, Орос, Америк, Герман улсад бүртгэлтэй хостуудаас хийсэн халдлагууд бүртгэгдэж байна Сүүлийн зургаан сарын хугацаанд өдөрт дунджаар 66 сая орчим хандалт хийгдэж байгаагаас 14,6 сая орчим нь халдлагын шинжтэй гэж бүртгэгддэг Төрийн байгууллагуудад чиглэж буй цахим халдлагад мэдээлэл хулгайлах зорилготой халдлагууд дийлэнх хувийг эзэлдэг байна

Цагдаагийн ерөнхий газрын 2020 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээгээр Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэг 2019 онд улсын хэмжээнд 57 тохиолдол байсан бол 2020 онд 146 болж 3 дахин нэмэгдсэн байна¹

Нэгдсэн үндэстний байгууллагын төрөлжсөн агентлаг болох Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас гишүүн 193 орны хүрээнд гаргадаг кибер аюулгүй байдлын индексийг тухайн улсын хууль эрх зүйн орчин, техникийн хувьд хэрэгжүүлж буй арга хэмжээ /үндэсний CIRT байгууллага, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад тавигдах стандарт, шаардлагууд/, зохион байгуулалтын арга хэмжээ /үндэсний стратеги, хөтөлбөрийн баримт бичиг, түүнийг хэрэгжүүлэх байгууллага/ чадавх бүрдүүлэх /үндэсний цахим аюулгүй байдлын сургалтын тогтолцоо/, хамтын ажиллагаа /олон улсын гэрээ, хэлцэлд нэгдсэн байдал, бусад орнуудтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээ, дотоодын байгууллагууд хоорондын хамтын ажиллагаа/ гэсэн үндсэн үзүүлэлт, 25 дэд үзүүлэлтийн хүрээнд гаргадаг Манай улсын хувьд хамгийн гол үзүүлэлт болох хууль эрх зүйн орчин бүрдээгүй, үндэсний CIRT байгууллага байхгүй, хамтын ажиллагаа дутмаг зэрэг

¹ /<https://police.gov.mn/a/5428/>

үндэслэлээр 2017 онд 104 дүгээр байранд, 2018 онд 85 дугаар байранд эрэмбэлэгдсэн байна

Иймд Монгол Улсад төр, хүн, хуулийн этгээдийн кибер аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэх, аюул заналыг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, онц чухал мэдээллийн дэд бүтцийг хамгаалах хуулийн зохицуулалт зайлшгүй шаардлагатай байгаа тул Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Кибер аюулгүй байдлын тухай анхдагч хуулийн төсөл боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна

Хоёр.Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ, хуулийн төслийн ерөнхий бүтэц

Кибер аюулгүй байдлын тухай хуулийн төсөл нь 5 бүлэгтэй байна

Хуулийн төслийн нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, Кибер аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, нэр томъёоны тодорхойлолт, кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тогтооно

Хуулийн төслийн зорилтод кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны зарчим, эрх зүйн үндсийг тогтоох, кибер орчин дахь мэдээллийн бүрэн бүтэн, хүртээмжтэй, нууцлагдсан байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахаар тусгана

Хуулийн төслийн үйлчлэх хүрээ нь кибер аюулгүй байдлыг хангахтай холбогдон төр, хүн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг уялдуулан зохицуулах, зохион байгуулах, хяналтыг хэрэгжүүлэх харилцаанд үйлчлэх бөгөөд хамрах хүрээний хувьд төрийн байгууллага, онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага, кибер орчинд дундын мэдээллийн систем боловсруулах, хадгалах, түгээх, цахим тооцооллын үйлчилгээ эрхэлж буй хуулийн этгээд болон түүний хэвийн үйл ажиллагааг хангахад мэдээллийн технологийн чиглэлээр дэмжлэг үзүүлж буй хуулийн этгээд, гадаадын иргэн, хуулийн этгээдэд үйлчилнэ

Хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлж, энэ хүрээнд хэрэгжүүлэх кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ болон мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх харилцааг тогтооно

Хуулийн төслийн гуравдугаар бүлэгт кибер аюулгүй байдлыг хангах тогтолцоо буюу кибер аюулгүй байдлыг хангах талаар Улсын Их Хурал, Засгийн газрын бүрэн эрх, харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, харилцаа холбооны зохицуулах хороо, тагнуулын байгууллагын эрх, үүрэг, цагдаагийн байгууллага, төрийн бусад байгууллага, онц чухал дэд бүтэцтэй байгууллага, хувийн хэвшлийн байгууллага, иргэний үүргийг тогтооно

Хуулийн төслийн дөрөвдүгээр бүлэгт кибер халдлага, зөрчилтэй тэмцэх төвүүд, тэдгээрийн чиг үүргийн уялдаа холбоог хангах зохицуулалтыг тусгана

Хуулийн төслийн тавдугаар бүлэгт кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд тавих хяналт, хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох хугацааг тусгана

Гурав.Хууль батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар эдийн засаг, нийгмийн дараах нөлөө, үр дагавар гарна гэж үзэж байна

1 “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”, “Төрөөс мэдээлэл харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого 2017-2025” зэрэг баримт бичгүүдэд тусгагдсан мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилтуудыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэж, Монгол Улсын мэдээллийн аюулгүй байдлыг хангахад эерэг нөлөө үзүүлнэ

2 Кибер аюулгүй байдлыг хангах үндэсний тогтолцоо бүрдэж, кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хяналт тавих, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах боломж бүрдэнэ

3 Кибер халдлага зөрчилтэй тэмцэх төвүүдийг байгуулж, кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авах, нөхөн сэргээх үндэсний чадавхыг бэхжүүлнэ

4 Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг төр-хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа үр дүнтэй, шуурхай хэрэгжих нөхцөлийг бүрдүүлнэ

5 Иргэдийн кибер аюулгүй байдлын талаарх ойлголт, мэдлэг, хариуцлага дээшилж өөрийн эзэмшиж, ашиглаж байгаа мэдээллийн систем, төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангах чадавх сайжирна

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомж

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид бүрэн нийцэх бөгөөд шинээр боловсруулж байгаа Хүний хувийн мэдээлэлийг хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн тухай хуулийн төслүүдтэй нийцүүлэн хуулийн төслийг боловсруулна Кибер аюулгүй байдлын тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг хуулийн төслийг боловсруулна

---oOo---